



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗДТГ-ЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/136/СТА/ШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn


Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан.....	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	19
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ 7
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.ГАНБАТ ТАНАА

2021.02.25 № 2/150

танай _____ -ны № _____ -г

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 103 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2021 А4 ТООТ

• 005020140

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Хүрээмарал сумын ЗДТГ-ын дарга тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,161,179.22	117,217,111.22
33	АВЛАГА	3,066,881.22	7,066,881.22
335	Бусад авлага	3,066,881.22	7,066,881.22
3351	Байгууллагаас авах авлага	3,066,881.22	7,066,881.22
35	БАРАА МАТЕРИАЛ	61,207,298.00	40,616,430.00
354	Хангамжийн материал	54,111,298.00	36,551,430.00
35410	Бичиг хэргийн материал	1,912,475.00	1,912,475.00
35450	Барилгын засварын материал	459,000.00	459,000.00
35470	Бусад хангамжийн материал	51,739,823.00	34,179,955.00
35600	Мал амьтад	7,096,000.00	4,065,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	3,887,000.00	69,533,800.00
36300	Тэжээлийн нөөц	00.00	69,533,800.00
36600	Бусад нөөц	3,887,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,312,075,037.27	1,255,028,199.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,312,075,037.27	1,255,028,199.55
392	Биет хөрөнгө	1,298,255,037.27	1,240,570,699.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,469,632,846.00	1,492,944,846.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-368,764,478.04	-427,029,269.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,084,800.00	165,084,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,760,349.96	-84,871,149.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,358,692.03	135,471,112.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,636,374.41	-96,358,482.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	143,331,533.99	148,331,533.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,606,632.34	-100,617,690.89
39216	Дуусаагүй барилга, байгууламж	21,400,000.00	7,400,000.00
39217	Ном	215,000.00	215,000.00
393	Биет бус хөрөнгө	13,820,000.00	14,457,500.00
39301	Програм хангамж	1,170,000.00	1,420,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,170,000.00	-782,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,820,000.00	13,820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,380,236,216.49	1,372,245,310.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,380,236,216.49	1,372,245,310.77
51	Засгийн газрын хувь оролцоо	1,380,236,216.49	1,372,245,310.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	916,547,429.40	916,547,429.40
51101	Өмч: - төрийн	916,547,429.40	916,547,429.40
512	Хуримтлагдсан үр дүн	298,637,809.62	290,646,903.90
51210	Өмнөх үеийн үр дүн	298,637,809.62	298,637,809.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,990,905.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	165,050,977.47	165,050,977.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,380,236,216.49	1,372,245,310.77

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	481,181,900.00	533,110,306.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,023,900.00	85,385,920.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,023,900.00	85,385,920.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,023,900.00	85,385,920.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	840,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	114,423,900.00	84,545,920.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,158,000.00	449,008,386.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,665,000.00	11,240,686.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,665,000.00	9,956,686.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,493,000.00	437,767,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,493,000.00	437,767,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	511,661,110.72	541,101,211.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,661,110.72	541,101,211.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	471,129,147.72	483,442,553.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,435,213.00	233,561,843.00
210101	Үндсэн цалин	208,435,213.00	189,112,697.00
210102	Нэмэгдэл	00.00	44,449,146.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,541,432.00	29,430,250.00
210201	Тэтгэврийн даатгал	17,654,267.00	20,495,012.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,076,973.00	2,337,994.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,661,578.00	1,870,396.00
210204	Ажилгүйдлийн даатгал	377,148.00	425,029.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,771,466.00	4,301,819.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,901,189.00	20,343,395.00
210301	Гэрэл, цахилгаан	3,371,459.00	3,706,048.00
210302	Түлш, халаалт	13,529,730.00	16,637,347.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,476,083.00	31,620,372.00
210401	Бичиг хэрэг	2,608,500.00	3,521,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,309,210.00	24,587,125.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,473.00	980,547.00
210404	Ном, хэвлэл	596,400.00	658,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	192,500.00	1,512,400.00
2105	Нормативт зардал	00.00	781,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	781,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,264,651.00	28,465,568.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,149,072.00	28,015,568.00
210604	Урсгал засвар	5,115,579.00	450,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,034,500.00	4,522,000.00
210702	Дотоод албан томилолт	7,034,500.00	4,522,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,340,882.00	19,248,868.00

**Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,880,530.00	14,473,136
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,992.00	522,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,360.00	234,152.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	99,000.00	55,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,135,197.72	115,468,857.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,831,942.00	11,756,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	756,717.00	2,490,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,546,538.72	101,221,257.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,531,963.00	57,658,658.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,753,900.00	56,003,265.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,495,300.00	52,721,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,258,600.00	3,281,965.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,778,063.00	1,655,393.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,778,063.00	55,393.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-30,479,210.72	-7,990,905.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-30,479,210.72	-7,990,905.72

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	366,758,000.00	448,564,386.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	840,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	840,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	840,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	840,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,158,000.00	447,724,386.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,665,000.00	9,956,686.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,665,000.00	9,956,686.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,493,000.00	437,767,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,493,000.00	437,767,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	365,648,300.00	419,652,386.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,648,300.00	419,652,386.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,116,337.00	361,453,728.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,085,975.00	233,561,843.00
210101	Үндсэн цалин	156,873,675.00	189,112,697.00
210102	Нэмэгдэл	32,142,700.00	44,449,146.00
210105	Гэрээт ажлын хөлс	15,069,600.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,516,200.00	29,430,250.00
210201	Тэтгэврийн даатгал	17,351,000.00	20,495,012.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210202	Тэтгэмжийн даатгал	2,041,300.00	2,337,994.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,633,000.00	1,870,396.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,300.00	425,029.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,082,600.00	4,301,819.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	16,230,189.00	20,343,395.00
210302	Түлш, халаалт	3,371,459.00	3,706,048.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	12,858,730.00	16,637,347.00
210402	Тээвэр, шатахуун	24,443,483.00	33,220,372.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,539,500.00	3,521,700.00
210404	Ном, хэвлэл	20,345,610.00	24,587,125.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	769,473.00	980,547.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	596,400.00	658,600.00
2105	Нормативт зардал	00.00	781,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	781,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,236,462.00	445,000.00
210604	Урсгал засвар	1,696,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	4,540,462.00	445,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,034,500.00	4,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,034,500.00	4,522,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	35,011,952.00	19,253,868.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	30,485,000.00	14,478,136.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	499,992.00	522,500.00
210807	Газрын төлбөр	225,960.00	234,152.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,000.00	150,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,564,000.00	3,564,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,557,576.00	19,895,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,457,576.00	17,404,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,100,000.00	2,490,900.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,531,963.00	58,198,658.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,753,900.00	56,543,265.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
		1,109,700.00	28,912,000.00
		-1,109,700.00	-28,912,000.00

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00	00.00

2.4 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	902,727,429.40	3,812,104.84	388,421,883.88	1,294,961,418.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	902,727,429.40	3,812,104.84	388,421,883.88	1,294,961,418.12
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,185,789.61	-45,185,789.61
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	298,637,809.62	1,380,236,216.49
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	298,637,809.62	1,380,236,216.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	298,637,809.62	1,380,236,216.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,990,905.72	-7,990,905.72
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,547,429.40	165,050,977.47	290,646,903.90	1,372,245,310.77

2.5 Аудит хийгдсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	443,455,700.00	438,552,307.00	4,903,393.00	98.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	443,455,700.00	438,552,307.00	4,903,393.00	98.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,912,300.00	382,009,042.00	4,903,258.00	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,699,000.00	233,561,843.00	137,157.00	99.9
210101	Үндсэн цалин	189,421,800.00	189,112,697.00	309,103.00	99.8
210102	Нэмэгдэл	44,277,200.00	44,449,146.00	-171,946.00	100.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,926,200.00	29,430,250.00	495,950.00	98.3
210201	Тэтгэврийн даатгал	20,392,500.00	20,495,012.00	-102,512.00	100.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,383,400.00	2,337,994.00	45,406.00	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,906,800.00	1,870,396.00	36,404.00	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	476,700.00	425,029.00	51,671.00	89.2
210205	Эрүүл мэндийн даатгал	4,766,800.00	4,301,819.00	464,981.00	90.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,422,400.00	20,343,395.00	79,005.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	3,845,000.00	3,706,048.00	138,952.00	96.4
210302	Түлш, халаалт	16,577,400.00	16,637,347.00	-59,947.00	100.4
2104	Хангамж, бараа материалын зардал	34,842,100.00	34,820,372.00	21,728.00	99.9
210401	Бичиг хэрэг	3,528,600.00	3,521,700.00	6,900.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	24,587,300.00	24,587,125.00	175.00	100.0

**Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	991,000.00	980,547.00	10,453.00	98.9
210404	Ном, хэвлэл	658,600.00	658,600.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,716,600.00	4,712,400.00	4,200.00	99.9
2105	Нормативт зардал	781,400.00	781,400.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	781,400.00	781,400.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,445,700.00	24,445,000.00	700.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,000,000.00	24,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	445,700.00	445,000.00	700.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	4,546,900.00	4,522,000.00	24,900.00	99.5
210702	Дотоод албан томилолт	4,546,900.00	4,522,000.00	24,900.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,029,900.00	10,897,182.00	4,132,718.00	72.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,181,300.00	6,121,450.00	4,059,850.00	60.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	522,500.00	522,500.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	263,100.00	234,152.00	28,948.00	89.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	150,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	99,000.00	55,080.00	43,920.00	55.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23218700.00	23207600.00	11,100.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,718,700.00	20,716,700.00	2,000.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,490,900.00	9,100.00	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56543400.00	56543265.00	135.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,543,400.00	56,543,265.00	135.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,721,300.00	52,721,300.00	00.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,822,100.00	3,821,965.00	135.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	443,455,700.00	438,552,307.00	4,903,393.00	98.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	442,455,700.00	437,712,307.00	4,743,393.00	98.9
132001	Орон нутгийн төсвөөс	442,455,700.00	437,712,307.00	4,743,393.00	98.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	840,000.00	160,000.00	84.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	840,000.00	160,000.00	84.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	0	
620001	Удирдах ажилтан	3	3	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	0	
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0	

2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,356,686.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,356,686.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,356,686.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,356,686.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,356,686.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,356,686.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,356,686.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Л.Ганбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 сарын 03-аас 2021 оны 02 сарын 05-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.01.22-ны өдрийн 51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүрээмарал сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Монгол улсын засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргаас тавьж буй хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэх, сум, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хүрээмарал сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь 2020 онд Хүрээмарал сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны 3 дугаар улирлын нийт зардлын 315066.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6301.3 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 542512.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 10850.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1372245.3 мянган төгрөг болж өмнөх оноос 7990.9 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,161.2	117,217.1	49,055.9
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,066.9	7,066.9	4,000.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	65,094.3	110,150.2	45,055.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,312,075.0	1,255,028.2	(57,046.8)
Үндсэн хөрөнгө	1,921,012.9	1,964,687.3	43,674.4
Хуримтлагдсан элэгдэл	(608,937.8)	(709,659.1)	(100,721.3)
Нийт хөрөнгө	1,380,236.2	1,372,245.3	(7,990.9)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,380,236.2	1,372,245.3	(7,990.9)

Авлага дансны үлдэгдэл 7066.9 мянган төгрөг болж 4000.0 мянган төгрөгөөр өссөн нь "Элэг нэгтэн" ХХК-д "Цэрэг толгой" -д угталт, үдэлтийн хаалганы ажлыг гүйцэтгэхээр 2020.07.24-нд 8000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.08.11-нд 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110150.2 мянган төгрөг болж 45055.9 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сан болон хандив тусламжаар 60187.3 мянган төгрөгийн өвс тэжээл бэлтгэсэнтэй холбоотой малын тэжээлийн үлдэгдэл 69533.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1964687.3 мянган төгрөг болж 43674.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 28912.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 15262.4 мянган төгрөгийн ОНХСангаар хийгдсэн хөрөнгийг шилжүүлэн авсан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.11.06-ны өдрийн 108 дугаар тогтоолоор ашиглалтгүй 500.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1372245.3 мянган төгрөг болж 7990.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 534394.3 мянган төгрөг болж өмнөх оноос 53212.4 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 53212.4 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилт 109274.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 840.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 29877.9 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 26424.3 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал 542512.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 30724.1 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, гэрэл цахилгаан, түлш халаалт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, бараа үйлчилгээний төлбөр хураамж, бусад урсгал шилжүүлэг өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 450095.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 450095.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 360.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 450455.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд анх баталсан 450455.7 мянган төгрөгийг тодотголоор 7000.0 мянган төгрөгөөр бууруулж 443455.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 443455.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 442455.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 840.0 мянга, орон нутгийн төсвөөс 437767.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 9956.7 мянган төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 437712.3 мянган төгрөгийг зарцуулж, 1655.4 мянган төгрөгийг орон төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 137.2 мянга, НДШ 495.9 мянга, байр ашиглахтай холбоотой зардал 79.0 мянга, хангамж, бараа материалын зардал 21.7 мянга, томилолт зочны зардал 24.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 4132.7 мянга, бусад бараа үйлчилгээний зардал 11.1 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 70106	445,001,600.00	440,099,507.00	4,902,093.00	98.89
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304,955,600.00	304,076,542.00	879,058.00	99.71
УРСГАЛ ЗАРДАЛ	304,955,600.00	304,076,542.00	879,058.00	99.71
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,955,600.00	304,076,542.00	879,058.00	99.71
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	183,155,000.00	183,017,843.00	137,157.00	99.93
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,102,700.00	22,606,750.00	495,950.00	97.85
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,672,100.00	19,643,395.00	28,705.00	99.85
Хангамж, бараа материалын зардал	30,036,600.00	30,016,772.00	19,828.00	99.93
Нормативт зардал	531,400.00	531,400.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	24,000,000.00	24,000,000.00	0.00	100.00
Томилолт, зочны зардал	3,593,600.00	3,568,700.00	24,900.00	99.31
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,645,500.00	9,482,082.00	163,418.00	98.31
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	11,218,700.00	11,209,600.00	9,100.00	99.92
ХӨТӨЛБӨР 70106				
АРГА ХЭМЖЭЭ 80106				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,421,300.00	67,367,700.00	53,600.00	99.92
УРСГАЛ ЗАРДАЛ	67,421,300.00	67,367,700.00	53,600.00	99.92
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,421,300.00	67,367,700.00	53,600.00	99.92
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	50,544,000.00	50,544,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,823,500.00	6,823,500.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	750,300.00	700,000.00	50,300.00	93.30
Хангамж, бараа материалын зардал	4,805,500.00	4,803,600.00	1,900.00	99.96
Нормативт зардал	250,000.00	250,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	445,700.00	445,000.00	700.00	99.84
Томилолт, зочны зардал	953,300.00	953,300.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,649,000.00	1,648,300.00	700.00	99.96

**Хүрээмарал сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 70106				
АРГА ХЭМЖЭЭ 80802				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,343,400.00	55,343,265.00	135.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	55,343,400.00	55,343,265.00	135.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,721,300.00	52,721,300.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,622,100.00	2,621,965.00	135.00	99.99
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
ХӨТӨЛБӨР 70106				
АРГА ХЭМЖЭЭ 81102				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	12000000	12,000,000.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 70106				
АРГА ХЭМЖЭЭ 82212				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,281,300.00	1,312,000.00	3,969,300.00	24.84
УРСГАЛ ЗАРДАЛ	5,281,300.00	1,312,000.00	3,969,300.00	24.84
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,281,300.00	1,312,000.00	3,969,300.00	24.84
Бусад нийтлэг АҮТХураамж	5,281,300.00	1,312,000.00	3,969,300.00	24.84

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Статистикийн хэлтсээс хүн ам, орон сууцны тооллогын зардалд 180.0 мянга, хагас жилийн мал тооллогын шатахууны үнэнд 976.7 мянга, тендерийн орлого 840.0 мянга, өвс борлуулсны орлого 444.0 мянга, оготно устгалд 7200.0 мянга, 2016 оны нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт 1600.0 нийт 11240.7 мянган төгрөгийн орлого төвлөрч, үүнээс өвсний орлогыг ОНХСангийн дансанд, тендерийн орлогыг ЗДТГ-ын данс үндсэн дансанд тус тус шилжүүлэн бусад зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байгаа бөгөөд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээний 22549.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулсан эсэхийг хянаж үзэхэд орлогын 15 гүйлгээний 413130.8 мянга, зарлагын 4 гүйлгээний 60139.5 мянган төгрөгийн мэдээллийг байршуулж зарлагын 1 гүйлгээний өндөр настны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн 22549.7 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	92	4	
	Нийт	27	151	145	4	2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 3066.9 мянган төгрөгийн авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, холбогдох материалыг бүрдүүлж, хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх зөвлөмжийг өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19261.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16861.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1400.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа.

Байхгүй

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 19261.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5400.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 16861.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгөв. Үүнд:

1. "Элэг нэгтэн" ХХК-д "Цэрэг толгой" -д угталт, үдэлтийн хаалганы ажлыг гүйцэтгэхээр 2020.07.24-нд 8000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.08.11-нд бараа үйлчилгээний бусад зардлаас 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж ажлыг хийгээгүй тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 2020.07.24-ны өдрийн Хүрээмарал сумын Засаг даргын "Элэг нэгтэн" ХХК-тай байгуулсан гэрээний 6.3 "Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Элэг нэгтэн ХХК -д олгосон 4000,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Сумын Эрчим хүчинд ашиглаж байсан 35990.0 мянган төгрөгийн өртөгтэй япон улсад үйлдвэрлэгдсэн моторыг 2011 оны 4 сард "Шижир аранжин" ХХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулахаар тухайн үед Сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Сэмжиддоржтой гэрээ байгуулсан байна. Моторын түрээсийн авлага 3066.8 мянган төгрөг санхүүгийн тайланд авлагаар тусгасан. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байна.

Мөн дээрх 35990,0 мянган төгрөгийн өртөгтэй моторыг Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2019.01.04-ны өдрийн А/09 тоот албан бичгээр сумын ИТХТ-ээр хэлэлцүүлэн актлах шийдвэр өгсний дагуу Хүрээмарал сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.03.29-ны өдрийн 07 дугаар тогтоолоор акталж данснаас хасах шийдвэр гаргасны дагуу 2019 онд данснаас хассан байгаа тул энэ асуудлыг цаашид анхаарч завсрын аудитаар үзэх шаардлагатай байна. .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020.12.09-ны өдрийн А/95 дугаар тушаалын "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10. "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Мал эмнэлгийн үржлийн тасгийн 2017 онд ашиглалтад орсон 2494.8 мянган төгрөгийн өртөгтэй 1 мотоцикл, багийн дарга нарын 2018 онд ашиглалтад орсон 1660.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 ширхэг мотоцикл улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй байна

Энэ нь Авто тээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17¹.1 дэх "Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дансанд бүртгэлтэй 10794,8 мянган төгрөгийн 6 авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээжүүлэх албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сумын Эрчим хүчинд ашиглаж байсан 35990.0 мянган төгрөгийн өртөгтэй япон улсад үйлдвэрлэгдсэн моторыг 2011 оны 4 сард "Шижир аранжин" ХХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулахаар тухайн үед Сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Сэмжиддоржтой гэрээ байгуулсан байна. Моторын түрээсийн авлага 3066.8 мянган төгрөг санхүүгийн тайланд авлагаар тусгасан. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байна.

Мөн дээрх 35990,0 мянган төгрөгийн өртөгтэй моторыг Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2019.01.04-ны өдрийн А/09 тоот албан бичгээр сумын ИТХТ-ээр хэлэлцүүлэн актлах шийдвэр өгсний дагуу Хүрээмарал сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.03.29-ны өдрийн 07 дугаар тогтоолоор акталж данснаас хасах шийдвэр гаргасны дагуу 2019 онд данснаас хассан байгаа тул энэ асуудлыг цаашид анхаарч завсрын аудитаар үзэх шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 Илрүүлэлт

Сумын Засаг даргын 2020.07.22-ны өдрийн А/77 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Цаг уурын амьсгалын өөрчлөлтийн улмаас хур бороо орохгүй байгаагаас сумын нутаг дэвсгэр 80 хувь гантай байгаа тул малчид иргэдийн хүсэлтээр Улаанбаатар хотоос лам нар залж 7 сарын 30,31,8 сарын 1-ны өдрүүдэд нутаг ус тахих буян номын үйл үйлдэх арга хэмжээг зохион байгуулсан байна. Энэ арга хэмжээнд зарцуулах лам нарын унааны болон байр, хоолны зардалд 1400.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2.1.2 "Энэ журмын 2.1.1,2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл

Засаг даргын нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөрийн зардлыг зориулалт бусаар зарцуулах.

1.3 Өгсөн зөвлөмж

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Засгийн газрын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын дагуу зарцуулж байх

1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.1.Илрүүлэлт



Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байгаа бөгөөд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээний 22549.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.2

Эрсдэл

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

2.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу дээрх хугацаа хоцроож байршуулсан мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.5.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН
ОГНОО: 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.25

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БНА-2021/136/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	"Элэг нэгтэн" ХХК-д "Цэрэг толгой" -д угталт, үдэлтийн хаалганы ажлыг гүйцэтгэхээр 2020.07.24-нд 8000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2020.08.11-нд бараа үйлчилгээний бусад зардлаас 4000.0 мянган төгрөгийг шилжүүлж ажлыг хийгээгүй тайланд авлагаар тусгасан байна.	4000.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс 1400.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1400.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
3	2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3066.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар зөвлөмж өгсөн боловч одоо болтол барагдуулаагүй байна.	3066.8	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
4	Мал эмнэлгийн үржлийн тасгийн 2017 онд ашиглалтад орсон 2494.8 мянган төгрөгийн өртөгтэй 1 мотоцикль, багийн дарга нарын 2018 онд ашиглалтад орсон 1660.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 ширхэг мотоцикль улсын бүртгэлийн гэрчилгээ байхгүй байна	10794.8	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Л.Ганбат Б.Баттөмөр
ДҮН		19261.6			

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ